



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 9/60

Бор-Өндөр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, 2.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИАРМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын харъяат Батнадмид овогтой Цэнджав нь 2024 оны 05 сарын 01-ний өдрөөс 08-ны өдрүүдэд АНЭУ-ын Абу даби хотноо зохион байгуулагдах Азийн аварга шалгаруулах Тэмцээнд оролцох тул бүртгэлийн хураамж болох 520 000 (таван зуун хорин мянга) төгрөг, Монголын муайтай сонирхогчдын холбооноос зохион байгуулах "Өсвөр залуучуудын Монгол улсын аварга шалгаруулах муайтайн тэмцээн"-д Бор-Өндөр сумыг төлөөлж "Тас" клуб оролцох тул дэмжлэг үзүүлж 500 000 (таван зуун мянга) төгрөг, сумын заан Ц.Ренчиндоржийн нэрэмжит сумын аварга шалгаруулах, цол олгох үндэсний бөхийн барилдааны зохион байгуулалтын зардалд 1 600 000 (нэг сая зургаан зуун мянга) төгрөг, Насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах Гар бөмбөгийн тэмцээний зохион байгуулалтын зардалд 1 000 000 (нэг сая) төгрөгийг тус тус Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсугай.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах 3 620 000 (гурван сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ